АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 17 өдөр Дугаар А/30 Эрдэнэбулган сум

"Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний
чанар, аюулгүй бэлэн байдлын аян" зарлах тухай

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/422 дугаар тушаал, 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/518 дугаар тоот тушаал, Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/15 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй бэлэн байдлыг сайжруулах нэг сарын аян зохион байгуулсугай.

2.Аяны удирдамжийг нэгдүгээр, өөрийн үнэлгээний хуудсыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй, бэлэн байдлын аяны үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Уран-Учрал/-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнаж ажиллахыг удирдлага мэдээллийн хэлтсийн дарга /Б.Азжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА Р.ГАНДИЙМАА

6512000096

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 02 сарын 17 өдрийн
А/30 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БЭЛЭН БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ НЭГ САРЫН АЯНЫ УДИРДАМЖ

Нэг. Өөрийн үнэлгээ хийх, зөвлөмж хэрэгжүүлэх

1. Энэхүү тушаалын дагуу нийт эрүүл мэндийн байгууллагууд өөрийн эрүүл мэндийн байгууллагад хяналт үнэлгээний хуудсаар үнэлгээг үнэн бодитоор 2020.02.20-ны дотор хийж эрүүл мэндийн газрын хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд ирүүлэх.
2. Эрүүл мэндийн газрын хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, чиглэл хариуцсан мэргэжилтэнүүд хамтран 2020.02.20-29-ны дотор хяналт үнэлгээ хийж мэргэжлийн хяналтын шалгалтанд бэлэн байдлыг тус тус хангаж ажиллах.
3. Өөрийн үнэлгээг мэргэжилтэнүүд дээд удирдлагад танилцуулах.
4. Үнэлгээний дагуу гарсан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, нэгдсэн тайлан гаргах
5. Өөрийн үнэлгээний тайланг хүлээн авсан улиралд багтааж түүвэр аргаар үгэлгээг хөндлөнгийн багаар ЭМГ-аас шуурхай хийнэ. Үнэлгээний зөвлөмж гаргах
6. Зөвлөмжийн хэрэгжилтийг 7 хоногийн дотор хийж, гүйцэтгэлийг нэг сарын дотор эрүүл мэндийн газарт ирүүлнэ.
7. Үнэлгээ нь хоёр үе шаттай явна.

   I. Нэгдүгээр үе: Өөрийн үнэлгээ, зөвлөмж
   II. Хоёрдугаар үе: Хөндлөнгийн үнэлгээ, зөвлөмж

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны ..02.. сарын ..17.. өдрийн
А/30 тоот тушаалын 2 дугаар хавсралт

**ЭМНЭЛГИЙН ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

## А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ХШҮ эхэлсэн: 20___ он ___ сар ___ өдөр, ___ цаг ___ мин; Дууссан: 20___он___ сар___ өдөр, ___ цаг___ мин;

<table>
<tr><td>Хяналт шалгалтын төрөл</td><td>Удирдамж</td><td colspan="2">Хяналт шалгалтын бүрэлдэхүүн</td></tr>
<tr><td>Тусгайлсан<br>Гүйцэтгэлийн</td><td>Дугаар</td><td colspan="2"></td></tr>
<tr><td colspan="4">Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага</td></tr>
<tr><td colspan="3">Нэр Улсын бүртгэлийн гэрчилгээний No<br>төрийн<br>хувийн</td><td>Регистрийн No</td></tr>
<tr><td colspan="2">Тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрөл</td><td colspan="2">Тусламж үйлчилгээний чиглэл /+/ тэмдэглэнэ.</td></tr>
<tr><td colspan="2">Чиглэл /тохирохыг + тэмдэглэнэ/<br>1. Клиник</td><td colspan="2">1.Дотрын өвчин судлал<br>2. Мэдрэлийн өвчин судлал<br>3. Нүдний өвчин судлал<br>4.Чих хамар хоолойн өвчин<br>5.Шүд эрүү нүүрний өвчин судлал<br>6.Хүүхдийн өвчин судлал<br>7.Мэс заслын өвчин судлал<br>8.Төрөх эмэгтэйчүүдийн өвчин<br>9.Халдварт өвчин судлал<br>10.Хавдар судлал<br>11.Гэмтэл согог судлал<br>12.Сэтгэцийн өвчин судлал<br>13.Арьс халимын өвчин судлал<br>14.Уламжлалт анагаах ухаан<br>15.Цус, цусан бүтээгдэхүүн судлал<br>16.Эмгэг судлал<br>17.Сувилахуй<br>18.Бусад.........</td></tr>
<tr><td colspan="4">Нийт ажилтны тоо................</td></tr>
<tr><td>Их эмчийн тоо......</td><td>Халдвар судлагч эмчийн тоо......</td><td>Сувилагчийн тоо...........</td><td>бусад.........</td></tr>
</table>